

## **ХЯНАЛТ ШАЛГАЛТ,ДОТООД АУДИТЫН ТАСГИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЧМЭЛ ТАЙЛАН**

Малчнаар ажиллаж байсан хугацааг тогтоох “Сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх орон тооны бус байнгын зөвлөл”-ийн тогтоолд аудит хийж гүйцэтгэсэн. Засаг даргын дэргэдэх орон тооны бус байнгын зөвлөл нь 20 сумын 2018 онд 46 даатгуулагчийн, 2019 онд 24 даатгуулагчийн, 2020 онд 69 даатгуулагчийн, 2021 онд 39 даатгуулагчийн, 2022 онд 20 даатгуулагчийн, нийт 198 даатгуулчийн мал маллаж байсан хугацааг тогтоосон тогтоол гарган ажилласан байна. 2018-2022 онуудад Улиастай, Сонгино, Ургамал, Эрдэнэхайрхан сумуудын зөвлөл хуралдаж тогтоол гаргаагүй байгаа бөгөөд эдгээр сумуудын малын А данс нь архивт бүрэн хадгалагдсан байна. Тайланг хугацаанд хүргүүлсэн.

2023 оны жилийн эцсийн байдлаар “Шилэн дансны хууль”-ийн хэрэгжилтэд аудит хийж гүйцэтгэсэн. Шилэн дансны цахим хуудсанд “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу тайлант хугацаанд тусгай зориулалтын сангийн мэдээллийг 163 удаа оруулахаас хугацаандаа оруулсан 155, хугацаа хоцороон 8 мэдээлсэн байна. Хэлстийн үйл ажиллагааны зарцуулалтын мэдээллийг 163 удаа оруулахаас хугацаандаа оруулсан 156, мэдээллийг хугацаа хоцороон 7 мэдээлсэн байна. Мэдээллийг хоцроосон шалтгаан нь шилэн дансны мэдээлэл оруулах цэсэнд тус хэлтсийн тусгай сангийн болон урсгал үйл ажиллагааны зардлын зарим мэдээлэл оруулах цэсийг сонгох боломжгүй байсан ба ДАМГазарт ханган мэргэжил арга зүйн зөвөлгөө авч админ эрхээр нэмж оруулж мэдээлсэн.

НДЕГ-ын даргын 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдөр баталсан удирдамжийн дагуу 2017-2022 оныг дуусталх хугацааны тус хэлтсийн сангийн болон хэлтсийн үйл ажиллагааны зардлын гүйцэтгэлд төлөвлөгөөт хяналт шалгалтыг Хяналт шалгалтын газраас хийж гүйцэтгэхэд үндэслэлгүй баримт бичиг бүрдүүлэн шүүхийн шийдвэр гаргуулж тэтгэвэр тогтоолгон авсан 46 иргэнтэй холбоотой 507,5 сая төгрөгийн, нийгмийн даатгалын байцаагчийн алдааны улмаас шалтгаалан 16 иргэнтэй холбоотой 23,6 сая төгрөгийн, нийт 531,2 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

НДЕГ-ын даргын 2023 оны А/69 дүгээр тушаал “ Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай”-ын дагуу 7 арга хэмжээ 27 ажил үйлчилгээ бүхий төлөвлөгөө хэлтсийн даргаар батлуулан ажиллаж байна. Төлбөр зөрчийг барагдуулах Улсын байцаагчийн үйлдсэн төлбөр зөрчлийн актаас 153,8 сая төгрөгийг барагдуулан ажиллаж байна. Актын биелэлт 28,9 хувьтай байна.

### **ДОТООД ХЯНАЛТЫН ТАЛААР:**

2023 оны дотоодын хяналт шалгалтын нэгдсэн удирдамжийг хэлтсийн даргаар батлуулан тэтгэвэр тэтгэмжийн тогтоолт олголтыг сан тус бүрээр шалгасан бөгөөд жилийн эцсийн байдлаар:

**Тэтгэвэр:** Тэтгэврийн даатгалын сангаас олгогдсон тэтгэвэрт шалгалтыг хийж гүйцэтгэхэд 12 сумын 27 тэтгэвэр авагчтай холбоотой 108,4 сая төгрөгийг илүү, 11 тэтгэвэр авагчид 3,3 сая төгрөгийг дутуу, нийт 111,8 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрсэнд Улсын байцаагчийн акт үйлдэж 75,2 сая төгрөгийг барагдуулсан. Актын биелэлт 67,3 хувьтай байна.

**Ажилгүйдэл:** 2022 онд ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж авсан 387 даатгуулагчдын анхан шатны баримт тогтоолт олголтод хяналт шалгалтыг хийж гүйцэтгэхэд 8 даатгуулагчтай холбоотой 5,4 сая төгрөгийн илүү, 3 даатгуулагчтай холбоотой 2,5 сая төгрөг дутуу, нийт 7,9 сая төгрөгийн зөрчил илэрч Улсын байцаагчийн акт үйлдэж 7,9 сая төгрөгийн төлбөрийг барагдуулж актын биелэлт 100 хувьтай байна.

**Тэтгэмж:** Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авч байх хугацаандаа хөдөлмөрийн чадвар түр алдалтын тэтгэмжийн 1-5 хоног давхардуулан авсан 7 даатгуулагчтай холбоотой 334,4 мянган төгрөг илүү, оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй 1 даатгуулагчид 1000,0 мянган төгрөгийг үндэслэлгүй илүү олгосон зөрчил илэрч Улсын байцаагчийн акт үйлдэж 1334,4 мянган төгрөгийг барагдуулж **100** хувийн биелэлттэй байна.

Дотоодын хяналт шалгалтаар нийт 121,1 сая төгрөгийн зөрчил илэрч Улсын байцаагчийн акт тогтоогдсоноос 84,4 сая төгрөгийг барагдуулан ажиллаж байна. Актын биелэлт 70,1 хувьтай байна.

Хэлтсийн даргын 2023 оны 11 сарын 10-ны өдрийн А/34 тоот тушаалаар тэтгэврийн хувийн хэргийн хагас жилийн хяналтын тооллогын ажлын хэсэг томилогдон тооллогыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн А/246 дугаар тушаалаар баталсан тэтгэврийн хувийн хэргийн тооллогын дэлгэрэнгүй бүртгэлийн нэгтгэл /ЗН-НД-6/, тэтгэвэр авагчдын хувийн хэргийн тооллогын нэгтгэл /ЗН-НД-7/ маягтын дагуу хийж 12379 тэтгэврийн хувийн хэрэг тоологдсон бөгөөд дутсан хувийн хэрэг байхгүй. 2022-2023 оны жилийн эцсийн байдлаар нас барсан, зогсоогдсон тэтгэвэр авагчийн олголтыг мэдээллийн нэгдсэн санд тулгуурлан шалгахад нас барсан 16 тэтгэвэр авагчийн хөдөлгөөний мэдээг тэтгэврийн програмд оруулгүйн улмаас 10310,0 мянган төгрөг илүү, тахир дутуугийн тэтгэвэр авагчийн хөдөлмөрийн чадвараа алдалтын хугацааг дууссан байхад зогсоогдсон хөдөлгөөнийг хийгээгүй, 15 тэтгэвэр авагчид 5060,9 мянган төгрөгийг дутуу, нийт 18267,1 мянган төгрөгийн зөрчилд Улсын байцаагчийн акт үйлдэж 9206,1 мянган төгрөгийн зөрчил төлбөрийг барагдуулсан. Актын барагдуулалт 90,1 хувьтай байна.

Зөрчлийн тухай хуульд заасны дагуу 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хойших хугацаанд хүүхдээ асрах чөлөөтэй байсан эхүүдийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой асуудлаар 12 ажил олгогчийн 18 даатгуулагчийн өргөдлийн дагуу “Гомдол мэдээлэл хүлээн авахаас татгалзсан” хэрэг үүсгэн аймгийн прокурорын байгууллагаар хянуулан хууль заасан хугацаанд шийдвэрлэсэн бөгөөд хугацаандаа төлөгдөөгүй 305,9 мянган төгрөгийн шимтгэл болон түүнд ногдох алдангийг “Зөрчлийн талаарх гомдол, мэлээллийг хүлээн авахаас татгалзсан материал” хүлээн авч шийдвэрийг Прокурорын байгууллагаар хянуулан хугацаандаа төлөгдөөгүй шимтгэлийг нөхөн төлүүлсэн. “Зөрчлийн тухай хууль”-ийн 10 дугаар зүйлийн 10.17.4 дахь заалтын дагуу 1 ажил олгогчид 250,0 мянган төгрөгийн торгуул ногдуулан төлбөрийг бүрэн барагдуулсан. Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилт ханган ажиллаж байна. Аймгийн прокурорт сар бүр мэдээгээ гарган хүргүүлсэн. Мөн оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх хугацаанд “Нийгмийн даатгалын тухай” хуульд заасны дагуу даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийг төлөөгүй орхигдуулсан 18 ажил олгогчийн 57 даатгуулагчийн өргөдлийн дагуу шалган Улсын байцаагчийн актаар 5214,4 мянган төгрөгийн төлбөр зөрчлийг тогтоон бүрэн барагдуулсан.

Цахим хяналтын веб програмд 24 сумын 1876 даатгуулагчтай холбоотой зөрчил илэрсэн. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/182 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан илгээх, хүлээн авах, хянах, баталгаажуулах журам”-ын 7.1-д заасан холбогдох баримт бичгийг бүрдлийг шалган

зөвшөөрсний үндсэн дээр Санхүү бүртгэлийн тасгийн дарга залруулгыг хийж гүйцэтгэж байна. Гүйцэтгэл 90,9 хувьтай байна.

Тайлант онд өмч хамгаалах зөвлөл нь нийт 4 удаа хуралдсанаас хагас, бүтэн жилийн тооллогын комиссын дүнг өмч хамгаалах зөвлөлөөр 2 удаа хэлэлцсэн ба дутагдалтай хөрөнгө байхгүй. Мөн элэгдлээрээ өртөгөө нөхөж, үлдэх өртөггүй болсон 5 нэрийн 20 ширхэг 3072,2 мянган төгрөгийн хөрөнгийн актлуулах, 7 нэр төрлийн 17 ширхэг 4947,1 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлэх саналыг хүлээн авч хэлэлцэн НДЕГ-ын Санхүү бүртгэлийн газар хүргүүлсэн.

НДЕГ-ын даргын баталсан “Нийгмийн даатгалын хуримтлагдсан авлагыг барагдуулах ажлыг эрчимжүүлэх, хамралтыг нэмэгдүүлэх” нэгдсэн удирдамжийн дагуу хэлтсийн даргаар 15 ажил үйлчилгээ бүхий төлөвлөгөө батлуулан тусгагдсан ажил үйлчилгээний дагуу хийж гүйцэтгэж 2022 оны жилийн эцсийн байдлаарх 179 аж ахуйн нэгж байгууллагын 356017,4 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлагдсан өр авлагаас 123 байгууллагын 253,6 сая төгрөг буюу нийт авлагын 71,2 хувийг барагдуулсан.

### **НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН ТАЛААР:**

Нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч нь эрдсэлийн үнэлгээ, төлөвлөлт, төлөвлөгөөт хяналт шалгалт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон ЗГ-ын 2022 оны 479 дүгээр тогтоолын дагуу хийж гүйцэтгэсэн.

**Эрсдэлийн үнэлгээний талаар:** Тайлант онд [www.shilenkhyanal.gov.mn](http://www.shilenkhyanal.gov.mn) цахим системд 404 объектыг эрсдэлийн үнэлгээ хийсэн ба үүнээс 86 объект их, 282 объект дунд, 32 объект бага эрсдэлтэй үнэлж, эрсдэлийн үнэлгээ хийж гүйцэтгэсэн.

**Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх объектын талаар:** Нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр 2023 онд уул уурхай, боловсруулах, боловсрол, барилга, эрчим хүч, дулаан, зам тээвэр гэсэн 6 чиглэлээр хяналт шалгалт хийхээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас чиглэл ирсний дагуу тус аймагт 2023 онд барилга эхлүүлэх зөвшөөрөл авсан 15 аж ахуйн нэгж байгууллага, уул уурхайн 2 аж ахуйн нэгж, байгууллага, МСҮТөв 1, Тосонцэнгэл сум дахь МСҮТөв 1, боловсруулах 1 аж ахуйн нэгж, нийт их эрсдэлтэй үнэлэгдсэн 19 ААНБ-ын жагсаалт гарган төлөвлөгөөний төслийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын хяналтын газарт хүргүүлсэн ба Хяналт шалгалтын төлөвлөгөөг Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/42 тоот тушаалаар барилгын 14, уул, уурхайн 2, боловсруулах 1, МСҮТөв 2, нийт 19 объектод төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийхээр баталсан. Тайлант хугацаанд 15 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, 7.3.1 кодтой Ажилтны нийгмийн хамгааллыг шалгах хяналтын хуудсаар эрсдэлийн түвшинг үнэлэхэд хууль тогтоомжийн биелэлт 74.8 %, эрсдэл үүсэх магадлал 25.2% буюу “Бага ” эрсдэлтэй үнэлэгдсэн. Мөн шалгалтаар давхардсан тоогоор 156 зөрчил илрүүлж, 32 зөрчлийг шалгалтын явцад арилгуулан 59 зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн хугацаатай 59 заалт бүхий 15 албан шаардлага хүргүүлэн ажилласан.

#### **Урьдчилан сэргийлэх хяналтын чиглэлээр:**

1. НДЕГ-ын даргын баталсан “Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх нэгдсэн удирдамж”-ын дагуу шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Шалгалтаар аймгийн ХХҮГазраас 2021 онд НХСангаас 1461 тэтгэвэр авагч, НДСангаас 11967 тэтгэвэр авагч, 2022 онд НХСангаас 1459 тэтгэвэр авагч, НДСангаас 12522 тэтгэвэр авагч, 2023 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар НХСангаас 1455 тэтгэвэр авагч, НДСангаас 12519 тэтгэвэр авагчийг хүн тус бүрээр тулган шалгахад 43 тэтгэвэр авагч давхардан авч байгаа боловч тэтгэврийн төрөл

давхардуулан аваагүй байсан ба шалгалтын дүнг НДЕГ-ын газрын ХШГазарт хугацаанд нь хүргүүлсэн.

2. Салбарын хяналтын газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 07/09 тоот удирдамжаар аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Нийгмийн халамжийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалтад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, шалгалтаар нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмжийг 21 иргэнд илүү, дутуу олгосон 2565.3 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, нэр бүхий 16 тэтгэвэр, тэтгэмж авагчдад илүү олгосон 1929.8 мянган төгрөгийг нийгмийн халамжийн санд нөхөн төвлөрүүлэхээр, 5 тэтгэвэр, тэтгэмж авагчдад дутуу олгосон 635.5 мянган төгрөгийг нөхөн олгуулахаар улсын байцаагчийн 3 заалт бүхий 2 акт үйлдэж, шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн 6 заалт бүхий албан шаардлага хүргүүлэн ажилласан. Актын барагдуулалт 591.5 мянган төгрөг буюу 22.2 %, албан шаардлага 86.0% биелэлттэй байна.

3. Салбарын хяналтын газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 24-ны өдрийн 07/22 тоот удирдамжаар аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021-2022 оны бүрдүүлэлт, зарцуулалтад төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил, дутагдлуудыг арилгах, төслийн үр дүн, ач холбогдлыг сайжруулах, төсөл хөтөлбөр, үйлчилгээнд хэрхэн хамруулах талаар холбогдох мэргэжилтнүүдэд заавар зөвлөгөө өгч, 3 заалт бүхий улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлэн ажилласан. Албан шаардлагын биелэлт ирүүлэх хугацаа болоогүй.

**Сургалт сурталчилгааны талаар:** Тайлант хугацаанд хууль эрх зүйн мэдлэг болон мэргэжлийн ур чадвар, арга зүйг дээшлүүлэх 44 удаагийн танхим болон цахим сургалтуудад хамрагдсан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас хамтран зохион байгуулсан хяналтын чиг үүргийн шилжилт ба шинэчлэлтэй холбоотой “Бодлого-Хэрэгжилт-Хяналт” сэдэвт 2.0 кредит цагийн нэгдсэн сургалт, Удирдлагын академиас зохион байгуулсан Алсын хараа-2050 зайны сургалт, Нийгмийн даатгалын багц хуулийн төслийн хэлэлцүүлэг, байгууллагаас 4 дэх өдөр болгон зохион байгуулдаг дотоодын сургалт болон төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 сургалт, хэлтсийн улсын байцаагчдын нэгдсэн сургалт, мөн бусад байгууллагаас зохион байгуулсан сургалтуудад тухай бүрд нь хамрагдсан.



### **ЭМНЭЛЭГ ХӨДӨЛМӨР МАГАДЛАХ КОМИССЫН АЖЛЫН ТАЛААР:**

Тус комисс нийгмийн даатгалын хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, ЭХМТөв комиссоос ирүүлсэн зөвлөмж, чиглэлүүдийг хэрэгжүүлэн ажиллаж, комиссын эмч нарын сонгон

шалгаруулалтыг зохион байгуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан 10 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр хуралдаж цахимаар болон иргэд даатгуулагчдыг байлцуулан хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоох сунгах, цуцлах, хөдөлмөрийн нөхцөл солих, ажлын цаг богиносгох зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэн долоо хоног бүрийн пүрэв гаригт хуралдаж, Тосонцэнгэл, Түдэвтэй сумдад нүүдлийн хурлын зохион байгуулан иргэд, даатгуулагчдад ойр нийгмийн даатгалын үйлчилгээг түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэхээр ажилласан.

Тайлант хугацаанд 7 хоног бүрийн пүрэв гаригт нийт 41 удаагийн хурлыг хийсэн. Үүнээс 37 удаагийн суурин хурал, 4 удаагийн нүүдлийн хурлыг зохион байгуулсан. 2602 хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг магадласнаас 265 хүнийг шинээр тогтоож, 2054 хүнийг сунгаж, 225 цуцалсан, 58 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг оношийн үндэслэл, оношлогоо, шинжилгээ хангалтгүй шалтгааны улмаас буцаасан шийдвэр гаргасан.

Нүүдлийн хурлыг Тосонцэнгэл, Түдэвтэй сумдад 4 удаа зохион байгуулж иргэнийг 361 сунгаж, 18 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцалсан шийдвэрийг гаргасан. Хурлын үеэр иргэдэд болон сумын эмч нарт Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм, журам, Дотрын өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдалттай болохоос урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулан, комиссын гишүүд нь сумын эмч нарын асуултад хариултуудыг өгч ажиллалаа.







Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг тогтоолгосон 1659 хүн нийгмийн даатгалын сангаас, 1130 хүн нийгмийн халамжийн сангаас тус тус тэтгэвэр авч байна.


Хувь хэмжээгээр хагас (хэсэгчлэн) алдсан буюу 50-69%-аар алдсан 1814, бүрэн алдсан буюу 70-100%-тай 975 иргэн байна.

Даатгуулагч (иргэн) Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоох, сунгах, цуцлах, ажлын цаг богиносгох шийдвэрүүдийг гаргахдаа Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр Нийгмийн хамгаалалын сайдын хамтарсан 2021 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/758, А/197 тоот тушаалыг 2022 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн мөрдөн ажиллаж байна. Завхан аймагт Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын бүрдмэл болон дахин магадлал зохион байгуулагдаагүй байна. Харин Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/39, А/12 тоот “Даатгуулагч /иргэн/-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг баримтлах өвчний жагсаалт, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг шинэчлэн батлах” тухай тушаал мөрдөгдөж эхлэхээс өмнө хугацаагүй магадласан 127 иргэнийг дотоодын дахин магадлалд дуудан эхний хагас жилийн байдлаар 95 хувьтай магадласан байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар хөдөлмөрийн чадвар алдалттай 2887 тэтгэвэр авагч иргэн байсан нь өмнөх оны үлдэгдлээс 3.4 хувиар буурсан буюу 2781 тэтгэвэр авагч байна.

2023 оны жилийн эцсийн байдлаар Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгож, бүртгэгдсэн өвчлөлийн түвшингээр аймгийн хэмжээнд эхний 5 байранд зонхилон тохиолдож байгаа ХЧА-ын шалтгааныг авч үзвэл:

1.	Сэтгэц болон зан үйлийн эмгэг өвчин	665	23.8 %
2.	Гэмтэл согогийн өвчин	532	18,9 %
3.	Дотрын өвчин	388	13,9%
4.	Мэдрэлийн өвчин	372	13,3 %
5.	Нүдний өвчин	316	11,3 %
6.	Бусад өвчлөл	516	18,8%-ыг тус тус эзэлж байна.

**Хөдөлмөрийн чадвар алдалтыг графикаар авч үзвэл**





Тосонцэнгэл, Түдэвтэй суманд нүүдлийн хурлыг зохион байгуулж 459 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг сунган, дахин магадлан ажилласан нь иргэдэд орон нутагтаа зардалгүй асран хамгаалагч нарт нь төвөггүй ач холбогдолтой байсан. Мөн иргэдэд нийгмийн даатгалд хамрагдан шимтгэл төлөх талаар сургалт хийж ажилласан.

Засгийн газрын тогтоол, Нийгмийн даатгалын ерөнхий газар болон ЭХМТК оос ирүүлсэн 2 удаагийн санал ирүүлэх, 6 албан тоот, ажиллах зөвлөмж зааврыг тухай бүр эмнэлэг хяналтын комисс болон эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын гишүүдэд танилцуулан хэрэгжүүлэн ажилласан. Мөн иргэд (даатгуулагч)-ээс ирсэн 3 өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн.



Эрхтэн тогтолцооны үйл ажиллагааны хүнд зэргийн дутагдалтай, зөөх, тээвэрлэх боломжгүй даатгуулагч (иргэн)-ийн хүсэлт, эмчлэгч эмчийн үзлэг дүгнэлт, эмнэлэг хяналтын комиссын саналыг үндэслэн хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ, хугацааг тогтоох асуудлыг Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын дүрмийн 3.1.2, 3.1.3-т заасаны дагуу цахим болон бичиг баримтад үндэслэн 65 иргэнийг шийдвэрлээд байна.

Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийн шилжилт хөдөлгөөний мэдээллийг цаг тухай бүрт нь Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын программд бүртгэн, хурал бүрийн дараа цахим эмнэлэг хөдөлмөрийн программд хурал бүрийн дараа мэдээллийн баазыг тавьж тэтгэвэр авагчдад чирэгдэл үүсгэлгүй ажилласан.


Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын гишүүдийн оролцоог сайжруулах зорилгоор дотоод ажил үүргийн хуваарийг хэлэлцэн баталж хэрэгжүүлэн ажиллаж байна.



Комиссын гишүүдийг удирдлага арга зүйгээр хангах болон иргэдэд мэдээллийг түргэн шуурхай хүргэх зорилгоор “Завхан ЭХМКомисс” нэртэй фэйсбүүк групп нээн эмнэлэг хөдөлмөрийн магадлалтай холбоотой хууль, дүрэм, зөвлөмж болон эмнэлэгийн хуудасны бичилт олголттой мэдээлэлийг оруулан иргэд даатгуулагчтай холбогдон ажиллаж байна.



Завхан аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагааг хүртээмжтэй болгох, иргэдэд ээлтэй орчин бүрдүүлэх зорилгоор хуучин хурлын байрыг өөрчлөн Нэгдсэн эмнэлгийн байранд хурлын өрөөг шийдвэрлүүлэн, тохижилтгүй байсан учир тохижуулахаар шаардлагатай тохижилт, тоног төхөөрөмжийн жагсаалтыг гарган хэрэгцээтэй хөрөнгийг дэмжүүлэхээр Аймгийн засаг даргын тамгын газарт хүргүүлсэн.




№	Байрны нэр, үйлчилгээний нэр	Төл шүүрэг	Нийт бүтцийн үнэ	НЭМ үнэ
1	Борлуулалтын байр	1	65,000,000	65,000,000
2	Навчур	1	150,000	150,000
3	Иргэдийн тусламжийн үйл бүрэлдэл	1	250,000	250,000
4	Нэгдсэн эмнэлэг	1	50,000	50,000
5	Сүрьеэ	1	250,000	250,000
6	Сүрьеэгийн үйлчилгээ	1	100,000	100,000
7	Малчид	1	15,000	15,000
8	Малчдын үйлчилгээ	1	300,000	300,000
9	Малчид	1	250,000	250,000
10	Иргэдийн (Иргэдийн зурвас)	1	20,000,000	20,000,000
11	Иргэдийн зурвас	2	25,000	50,000
12	Иргэдийн зурвас	1	300,000	300,000
13	Иргэдийн зурвас	1	80,000	80,000
14	Иргэдийн зурвас	2	550,000	1,100,000
15	Иргэдийн зурвас	2	150,000	300,000
16	Иргэдийн зурвас	1	300,000	300,000
17	Иргэдийн зурвас	30	25,000	750,000
18	Иргэдийн зурвас	1	300,000	300,000
19	Иргэдийн зурвас	1	1,500,000	1,500,000
20	Иргэдийн зурвас	1	1,500,000	1,500,000
21	Иргэдийн зурвас	10	100,000	1,000,000
22	Иргэдийн зурвас	1	150,000	1,500,000
23	Иргэдийн зурвас	1	30,000	300,000
24	Иргэдийн зурвас	1	150,000	1,500,000

Хоёр. Дотоодын хяналт шалгалтын талаар



Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яамны дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөлүүд болон Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс цахимаар зохион байгуулсан удаагийн аргачлал боловсруулах хэлэлцүүлэгт Эмнэлэг хяналтын комиссын гишүүд, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын гишүүдийг оролцуулсан.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагааны чанар, хүртээмжийг дээшлүүлэх тус магадлалын үйл ажиллагаанд оролцогчдын мэдлэг, ур чадвар, хариуцлага, түүнд тавих дотоодын хяналтыг сайжруулах зорилгоор зохион байгуулсан, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор Говь-Алтай аймаг болон Архангай аймгийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссуудтай хамтран ижил мэргэжилтний үзлэгийг зохион байгууллаа. Энэхүү "Ижил мэргэжилтний үзлэг" нь хяналтын болон төрөлжсөн мэргэжлийн эмч нарын амбулаторийн картын бичилт, оношийн баталгаажуулалт, түүнд тавьж буй дотоодын хяналтын өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгч, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцэж, эмнэлэг хөдөлмөр магадлалын үйлчилгээнд, оролцогч талуудын мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хариуцлагыг дээшлүүлэх. хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэх үйл ажиллагаа боловсронгуй болгох, эмнэлэг хөдөлмөрийн магадлалын сайн туршлагаас суралцах зэргээр иргэн (даатгуулагч)-д үзүүлэх эмнэлэг хөдөлмөр магадлалын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах арга замыг тодорхойлсноороо ач холбогдолтой болов.



Увс аймгийн сайн туршлага болох 1856 хүний амбулаторийн картыг өвчний оношоор өөр өөр өнгөөр ялган мэдээллийг шинэчлэн өнгө үзэмжийг сайжруулсан, Архангай аймагт зохион байгуулагдсан “Процессын дахин инженерчлэл” сургалтад Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын магадлагч эмч А.Цэрэнлхам, Нийгмийн халамжийн төлөөлөл Ц.Баттогтох нар оролцох үеэр тус аймгийн хурлын явцтай танилцсан. Мөн Архангай аймгийн хурлын явц онцлог давуу талуудыг харж амбулаторийн картны нүүр хэсэгт иргэний цээж зургыг байрлуулах сайн туршлагыг нэвтрүүлэхээр шийдвэрлэсэн.



4 төрлийн судалгааг гарган комиссын гишүүдэд танилцуулан цаашид хэрхэн бууруулах, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцэв.

### Гурав. Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийн байдалд дүн шинжилгээ хийсэн.

1. Завхан аймгийн Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийг нийт хүн амд харьцуулсан судалгааг гаргахад 3.9 хувь байна. 39.6 хувь нь Нийгмийн халамжийн сангаас, 60.4 хувь нь Нийгмийн даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр авч байна.

2. Өнгөрсөн 5 жилийн байдлаар Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хэмжээ тогтоолгосон иргэдийн хувь тогтмол буурсан үзүүлэлттэй байсан. Өвчний ангилалаар эхний 5 байрыг авч үзвэл Сэтгэц болон зан үйлийн эмгэг, Гэмтэл согогийн өвчин, Дотрийн өвчин, Мэдрэлийн өвчин, Нүдний өвчин байна.


3. Хөдөлмөрийн чадвар алдалсан иргэдийн сумын хүн амд харьцуулан үзэхэд 24 сумаас 19 сум нь улсын дундаж үзүүлэлтээс дээш байна.

4. Сум тус бүрээр өвчний ангилаар авч үзсэн судалгааг гаргасан.

### Дөрөв. Сургалт сурталчилгааны талаар

Д/д	Сургалтын нэр	Сургалт зохион байгуулсан байгууллага	Хамрагдсан хүний тоо	Хамтран зохион байгуулсан байгууллага
1	Сэтгэцийн өвчнөөр ХЧА-н хувь, хугацаа тогтооход анхаарах асуудал онлайн сургалт	НДЕГ-ЭХМТК	10	Сэтгэц судлалын мэргэжлийн салбар зөвлөл
2	Чих, хамар, хоолойн өвчнөөр ХЧА-н хувь, хугацаа тогтооход баримтлах аргачлалын хэлэлцүүлэг	НДЕГ-ЭХМТК	2	Чих, хамар, хоолойн мэргэжлийн салбар зөвлөл
3	Дотрийн өвчнөөр ХЧА-н хувь, хугацаа тогтооход баримтлах аргачлалын хэлэлцүүлэг	НДЕГ-ЭХМТК	3	Дотрийн анагаах ухаан судлалын мэргэжлийн салбар зөвлөл

4	Сэтгэгц өвчнөөр ХЧА-н хувь, хугацаа тогтооход баримтлах аргачлалын хэлэлцүүлэг	НДЕГ-ЭХМТК	3	Сэтгэгц судлалын мэргэжлийн салбар зөвлөл
5	Мэдрэлийн өвчнөөр ХЧА-н хувь, хугацаа тогтооход баримтлах аргачлалын хэлэлцүүлэг	НДЕГ-ЭХМТК	3	Мэдрэл судлалын мэргэжлийн салбар зөвлөл
6	Арьс, сүрьеэ, нүдний өвчнөөр ХЧА-н хувь, хугацаа тогтооход баримтлах аргачлалын хэлэлцүүлэг	НДЕГ-ЭХМТК	5	Арьс, халдварт, нүдний мэргэжлийн салбар зөвлөл
7	“Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь”, “Авилгын гэмт хэрэг”	НДЕГ-ЭХМТК	11	АТГ
8	2023 оны 11 дүгээр сарын 24-ны өдөр Аймгийн Прокурорыг газраас зохион байгуулсан “Авилга, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь”	Завхан Нийгмийн даатгалын хэлтэс	12	Аймгийн Прокурорын газар



БАТЛАВ  
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СОЁН  
ГЭГ ЗЭНГЭГҮЛЭХ ХЭЛТЭСИЙН ДАРГА,  
ЭРХСЭН КОМИССАР  
Х.ИХМӨРӨН

**ЗАРИМ АЙМГИЙН ТӨРИЙН АЛБАН ТУШААЛТНУУДАД  
ЗӨРИУЛСАН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

2023 оны 06 дугаар сарын 19-ны өдөр Улаанбаатар хот

Сургалтын зорилго: Нийтийн албан тушаалагчид тэмгэдэх хоргилт, хязгарилт, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдэгдэл, тайлбар гаргах, авилгын гэмт хэрэг, түүний хор уршг болон авилгын эсрэг хууль тогтоомжийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, орон нутагт нийтлэг гарч буй ашиг, ашиг сонирхлын зөрчлөд аюулаарх асуудлын талаар ойлголт, арга зүйн зөвлөгөө өгөх.

Сургалтын хугацаа: 2023 оны 06 дугаар сарын 21-ны өдөр 09:00 цагт /90 минут/

Сургалтад хамрагдах төлөвлөг: Нийгмийн даатгалын өрнөлийн газрын Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс, салбар болон орон нутгийн комиссын гишүүд

Сургалтын хэлбэр, үр дүнг хэмжих: Сургалтыг ZOOM meeting цахим холболт ашиглан хийнэ.

Сургалтын сэдэв	
08:50 - 09:00	Бүртгэл
09:00 - 09:30	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён агааруулгах хэлтсийн ашиглах комиссар Б.Баярлхам
09:30 - 10:00	Авилгын гэмт хэрэг Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён агааруулгах хэлтсийн ашиглах комиссар Г.Ундармаа
10:00 - 10:10	Асуулт хариулт, хаалт



